

“ХӨРСНИЙ НЯНГИЙН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ”  
АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 04 дүгээр сарын 19-ны өдөр

№ 5...

Улаанбаатар хот

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	
1.1. Захиалагч байгууллагын нэр, хаяг:	Нийслэлийн байгаль орчны газар Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Ц.Жигжиджавын гудамж-9, Бага тойруу-15160, Засаг захиргааны II байр 418 тоот
1.2. Санхүүжилтийн эх үүсвэр:	Нийслэлийн төсвийн хөрөнгө – Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардал
1.3. Төсөв:	130,000,000 (Нэг зуун гучин сая) төгрөг
1.4. Төсөл хэрэгжих талбай:	Улаанбаатар хотын нутаг дэвсгэр
1.5. Хамрах хүрээ:	Улаанбаатар хотын хэмжээнд 10 га нянгийн бохирдолтой нийтийн эзэмшлийн зам, талбай;
1.6. Ажил гүйцэтгэх үндэслэл	<ul style="list-style-type: none"><li>- Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого 9.2.1.2. дахь зорилт;</li><li>- “Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай” хуулийн 8.4.1. дэх заалтууд;</li><li>- “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 6.2.9. дэх зорилт;</li><li>- “Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ий 252 дахь зорилт;</li><li>- “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”- ний 5.2.6.2 дахь зорилт;</li></ul> НБОГ-ын Төсвийн шууд захирагчийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 5 дахь арга хэмжээ;
1.7. Ажлын зорилго:	Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 10 га нийтийн эзэмшлийн зам, талбайд хөрсний нянгийн бохирдлыг бууруулах;
1.8. Ажил гүйцэтгэх үе шат:	<p>1-р үе шат: Бэлтгэл үе</p> <ul style="list-style-type: none"><li>- Ажил гүйцэтгэх хуваарьт төлөвлөгөө боловсруулан захиалагчаар баталгаажуулах;</li><li>- Хөрсний дээж авах бэлтгэл ажлыг хангах;</li><li>- Дүүргүүдээс ирсэн хөрсний бохирдолтой талбайн саналыг судалж, бохирдлын хэмжээг тодорхойлох - Итгэмжлэгдсэн лаборатори байх; (өмнө ба дараа харьцуулах)<ul style="list-style-type: none"><li>o Эрүүл ахуйн үзүүлэлтүүд - Нянгийн тоо-E-Coli, Гэдэсний савханцрын титр, Анаэроб.</li></ul></li></ul> <p>2-р үе шат: Хээрийн ажил</p> <ul style="list-style-type: none"><li>- Хөрсний нянгийн бохирдолтой 10 га талбайд хэмжилт хийж, талбайг сонгох</li><li>- Хөрсний судалгааны ажлууд, шинжилгээний дүнд үндэслэн хөрсний бохирдолтой газрын хамрах талбай, бохирдлын үзүүлэлт, хөрсний шинж чанар, байгаль-цаг уурын нөхцөл зэрэгтэй</li></ul>

	<p>уялдуулан бохирдлыг бууруулах арга зүй, технологийг боловсруулж захиалагчаар батлуулах;</p> <p>3-р үе шат: Ажил гүйцэтгэх</p> <ul style="list-style-type: none"> <li>- Батлуулсан хөрсний бохирдлыг бууруулах арга, технологи, төлөвлөгөөний дагуу нүхэн жорлон буулгах, ариутгах арга хэмжээг хэрэгжүүлэх;</li> <li>- Батлуулсан хөрсний бохирдлыг бууруулах арга, технологи, төлөвлөгөөний дагуу бохирдол бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;</li> <li>- Хөрсний бохирдол бууруулсан талбайд шинжилгээ хийж үр дүнг харьцуулан дүгнэж тайлагнах;</li> <li>- Хөрсний бохирдол бууруулсан талбайг хүлээлгэн өгөх;</li> <li>- Шинжилгээний дүн болон талбайн мэдээллийг нэгдсэн мэдээллийн санд оруулах;</li> </ul> <p>Ажил гүйцэтгэлийг тайлагнах, үр дүнг үнэлүүлэх, холбогдох баримт бичгийг бүрэн хүлээлгэн өгөх;</p>
<b>ХОЁР. ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА</b>	
<p><b>2.1. Чадвар</b></p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Ажил гүйцэтгэгч нь дараах байгууллагууд байж болно: <ul style="list-style-type: none"> <li>- Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага</li> <li>- Ариутгах, халдваргүйжүүлэх ажил үйлчилгээ эрхэлж буй аж ахуй нэгж, байгууллага</li> <li>- Судалгаа шинжилгээний хүрээлэн, төв</li> <li>- Их дээд сургууль</li> <li>- Тухай чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд түншлэл хэлбэрээр оролцож болно.</li> </ul> </li> <li>2. Ажил гүйцэтгэгч нь 3-с доошгүй жил үйл ажиллагаа явуулсан ажил гүйцэтгэх багийн бүрэлдэхүүнд мэргэжлээрээ 3 болон түүнээс дээш хугацаанд ажилласан туршлагатай <ul style="list-style-type: none"> <li>o Үндсэн болон гэрээт ажилтан байх - хөрс судлаач-1, микробиологич-1, химич, химийн технологич-1, ургамал судлаач-1, ГМС мэргэжилтэн -1, биологич-1; /дээрхийн заавал нэг нь үндсэн байх/</li> </ul> </li> <li>3. Хөрсний бохирдлыг бууруулах, ариутгал халдваргүйжүүлэлт хийхэд шаардлагатай хүн хүч, техник, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй байна.</li> </ol> <p>Урьд өмнө нь ижил төстэй ажил, байгальд ээлтэй хоргүй, ашигтай бактериар ариутгалын ажил хийж гүйцэтгэж байсан бол давуу тал болно.</p>
<p><b>2.2. Техникийн болон бусад шаардлага:</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл, тендерийн баримт бичигт заасан холбогдох шаардлагыг хангасан байх;</li> <li>- Мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудын хувьд ажил гүйцэтгэхтэй холбоотой мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрөлийн хүчинтэй хугацаа дуусаагүй байх.</li> <li>- Ажил гүйцэтгэхтэй холбоотой ХАБЭА-н дотоод дүрэм журамтай байх, аюулгүй байдлыг хангах</li> <li>- Хууль тогтоомжийн хүрээнд ажиллах;</li> <li>- Урьд өмнө нь ижил төстэй ажил гүйцэтгэж байсан</li> </ul>

	<p>бол давуу тал болно;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хөрсний бохирдол, түүнийг бууруулах талаар судалгааны ажил гүйцэтгэх, хөрсийн дээж авах чадвартай байх;</li> </ul> <p>Ажил гүйцэтгэл дууссаны дараа үр дүнд мониторинг судалгаа хийх чадвартай байх;</p>
<b>2.3. Тусгай шаардлага</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Байгальд ээлтэй хоргүй технологи ашиглах, ашигтай бактериар ариутгалын ажлыг хийж гүйцэтгэх;</li> <li>- Хөрсний бохирдлыг бууруулах ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүн хүчтэй байна;</li> <li>- Ажил гүйцэтгэхэд шаардлагатай техник, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хүчин чадалтай байх;</li> </ul> <p>Мэргэжлийн, туршлагатай, чадварлаг хүний нөөцийн бүрэлдэхүүнтэй байх;</p>
<b>2.4. Холбогдох журам стандарт:</b>	<ul style="list-style-type: none"> <li>- MNS 6341 : 2012 Хөрсний чанар. Хөрсөнд эрүүлзүйн нян судлалын шинжилгээ хийх арга;</li> <li>- MNS ISO 18400-203 : 2022 Хөрсний чанар. Сорьц авах 203-р хэсэг: Бохирдсон байх магадлалтай газрыг шинжлэх;</li> <li>- MNS ISO 18400-201 : 2022 Хөрсний чанар - сорьц авах 201-р хэсэг: Хээрийн нөхцөлд хөрсний сорьцыг урьдчилан боловсруулах;</li> <li>- MNS ISO 18400-105 : 2022 Хөрсний чанар. Сорьц авах 105-р хэсэг: Сорьц савлах, тээвэрлэх, агуулах, хадгалах;</li> <li>- MNS 5850 : 2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ;</li> <li>- MNS 3297 : 2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх;</li> <li>- MNS ISO 11464 : 2002 Хөрсний чанар. Физик - химийн шинжилгээ хийх дээжийг урьдчилан боловсруулах</li> <li>- MNS 3675 : 1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга;</li> <li>- MNS 6838 : 2020 Байгаль орчин. Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах нефтийн бүтээгдэхүүнийг тодорхойлох жингийн арга;</li> <li>- MNS 5914 : 2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт</li> </ul> <p>MNS 5924:2015 Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага</p>
<b>ГУРАВ. ХЯНАЛТ, ШАЛГАЛТ, ТАЙЛАН</b>	
<b>3.1. Ажлын хяналт, шалгалт</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Гэрээт ажлын гүйцэтгэлд захиалагч талаас хүлээн зөвшөөрч баталсан календарьчилсан төлөвлөгөө, холбогдох гэрээ болон ажлын даалгаврын дагуу гүйцэтгэж буй эсэхэд шууд болон дүүрэгтэй хамтран хяналт тавьж ажиллана.</li> <li>- Захиалагч нь шаардлагатай үед хэдийд ч гүйцэтгэгчийн ажилтай танилцах эрхтэй ба ажлын гүйцэтгэлтэй холбоотойгоор нэмэлт мэдээ мэдээлэл гаргуулж авах эрхтэй.</li> </ul> <p>Хяналт, шалгалтын ажлыг захиалагч хариуцна.</p>
<b>3.2. Тайлан материал хүлээлгэн өгөх</b>	<p>Гүйцэтгэгч байгууллага нь дараах тайлан, баримт бичиг материалыг захиалагч байгууллагаас томилогдсон ажлын хэсэгт хүлээлгэн өгнө. Үүнд:</p>

	<ul style="list-style-type: none"> <li>- Ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын явцын тайланг сар бүр ирүүлэх /цаасаар болон цахимаар/;</li> <li>- Бүрэн хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хэвлэмэл болон цахим хэлбэрээр ирүүлэх;</li> <li>- Мэдээллийн санд мэдээлэл оруулах;</li> <li>- Хавсралт материалууд (фото зураг, бичлэг, бусад холбогдох материалууд);</li> </ul> <p>Ажлын тайлан болон хавсралт материалуудыг эх хувь болон хуулбар 3 хувийг хэвлэмэл байдлаар ирүүлнэ. Бүх материалыг цахим хэлбэрээр хүлээлгэн өгөхдөө ажлын нэр, дугаар, хаягтай DVD-д хуулж ирүүлнэ;</p>
<b>ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА</b>	
<p><b>4.1. Ажил эхлэх:</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Гэрээ байгуулснаас хойш 5 сарын хугацаанд гүйцэтгэнэ;</li> </ul> <p>Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэх календарьчилсан төлөвлөгөөг захиалагчид танилцуулан батлуулсны дараагаар ажлыг эхлүүлнэ;</p>

Хянасан:

ХӨРСНИЙ БОХИРДОЛ, ДОРОЙТЛЫГ  
БУУРУУЛАХ ХЭЛТСИЙН  
ДАРГА

(албан тушаал)

Б.ЖАВЗАНДУЛАМ

(гарын үсэг)

Боловсруулсан:

ХӨРСНИЙ БОХИРДОЛ, ДОРОЙТЛЫГ  
БУУРУУЛАХ ХЭЛТСИЙН АХЛАХ  
МЭРГЭЖИЛТЭН.....

(албан тушаал)

Г.САРАНЗАЯА

(гарын үсэг)